



2020 оны 11 дүгээр сарын 04
№41 /1143/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Эрүүл мэндийн даатгалын
үндэсний зөвлөлийн зарим
гишүүнийг чөлөөлөх, томилох
тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Төрийн өмчит их сургууль,
дээд сургууль, коллежийн
харьяа сургууль байгуулах
журам**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

454.	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	Дугаар 29	2234
------	--	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

455.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 107	2234
456.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 108	2235

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

457.	Журам батлах тухай	Дугаар 142	2235
458.	Жагсаалт батлах тухай	Дугаар 172	2239

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

459.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 08	2246
------	--	-----------	------



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14¹.2.1 дэх заалт, 14¹.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Содномын Чинзориг, Даваажанцангийн Сарангэрэл нарыг Засгийн газрыг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аюушийн Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан нарыг Засгийн газрыг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

3.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Т.АЮУРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 08 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан шүүгч Санжаагийн Амардэлгэрийг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 08 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан шүүгч Гомбодоржийн Гантуяаг Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 5.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн харьяа сургууль байгуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн харьяалалд үйл ажиллагаа явуулж байгаа технологийн болон политехник коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын ахлах сургуулийн үйл ажиллагаа явуулах



тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2020 оны
142 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ИХ СУРГУУЛЬ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙН ХАРЬЯА СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн харьяа сургууль (цаашид “харьяа сургууль” гэх) байгуулах харилцааг зохицуулна.

1.2.Харьяа сургууль байгуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, үр ашигтай, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр нөлөөтэй, улсыг хөгжүүлэх төлөвлөлт, стратегийн болон бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, салбарын хөгжил, чанарын шинэчлэлийг хурдасгахад үр нөлөөтэй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахуйц байх зарчмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Харьяа сургууль байгуулахад тавигдах шаардлага

2.1.Харьяа сургууль байгуулахад дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.дээд сургууль, коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулах хүсэлт гаргахдаа эдийн засаг, нийгмийн нөлөөллийн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний талаар судалгаа хийсэн байх;

2.1.2.сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөө боловсруулсан байх;

2.1.3. технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын ахлах сургууль нь багшлах эрхийн сургалтад хамрагдсан, мэргэжлийн зэрэгтэй үндсэн багшаар хангагдах боломжтой байх;

2.1.4.сургалтын зориулалтын байр, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, техник хэрэгсэл, кабинет, лабораторитой байх;

2.1.5.дараагийн шатлалд элсэж, дэвшин суралцах зохицуулалтыг хийсэн дүрэм, журам боловсруулсан байх;

2.1.6.дунд, урт хугацаанд үр ашигтай байх хөрөнгө оруулалт, үр ашиг, зардал, санхүүгийн тооцоолол хийсэн байх;

2.1.7.төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоог хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч тусгасан байх;

2.1.8.төрийн өмчит их, дээд сургууль, коллежийн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн байх;

2.1.9.сургалтын орчин нь суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангасан байх.

2.2.Дээд сургууль, коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулах асуудлаар холбогдох салбарын яамд, ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас санал авч болно.

Гурав. Хүсэлт гаргах, судалж шийдвэрлүүлэх

3.1.Энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан нөхцөлд төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагаас харьяа дээд сургууль, коллеж, технологийн коллеж, ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах хүсэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллеж байгуулах хүсэлтийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3.2.Төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагаас харьяа сургууль байгуулах тухай хүсэлт ирүүлсэн тохиолдолд боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий “Шинжээчдийн хэсэг”-ийг тус бүр томилж ажиллуулна.

3.3.Харьяа сургууль байгуулах хүсэлтийг шинжээчдийн хэсэг дэмжсэн дүгнэлт гаргасан бол боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль, журмын дагуу санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.



3.4.Шинжээчдийн хэсэг дэмжээгүй дүгнэлт гаргасан бол боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дүгнэлтийн үндэслэлийг тусгасан хариуг албан бичгээр хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.5.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь магадлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг томилохдоо бүрэлдэхүүнд нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг албан бичгээр санал авсны үндсэн дээр заавал оруулна.

3.6.Засгийн газраас харьяа сургуулийг байгуулах тухай шийдвэр гарсны дараа төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллага нь Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус заасны дагуу сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авч, сургалт эрхлэх үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

3.7.Харьяа сургуулийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

Дөрөв. Салбар сургууль байгуулах

4.1.Төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагын оршин байгаа газраас өөр газарт байрлах салбар сургууль (цаашид “салбар сургууль” гэх) байгуулах асуудлыг энэ журмын 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөхөөр хүргүүлнэ.

4.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрсөн тохиолдолд салбар сургууль байгуулах асуудлыг төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж эцсийн шийдвэрийг гаргана.

4.3.Салбар сургуулийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг боловсролын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

Тав. Бусад

5.1.Харьяа сургууль нь хуулийн этгээдийн хувьд холбогдох хууль, журмын дагуу байгуулсан удирдах болон сургуулийн зөвлөлтэй байна.

5.2.Харьяа сургууль нь магадлан итгэмжлэлд бие дааж орно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай болон Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг хөнгөлөх “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барааны жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Д.СУМЪЯАБАЗАР

Засгийн газрын 2020 оны
172 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАРИХ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧДЫН ХОТХОНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨ БИЙ БОЛГОХОД ШААРДАГДАХ, ДОТООДЫН ҮЙЛДВЭРЭЭС ХАНГАХ БОЛОМЖГҮЙ, ИМПОРТООР ОРУУЛЖ ИРЭХ БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Код	Барааны нэр
1.	2515.20.00	Барилгын зориулалттай экауссин болон бусад шохойн чулуу, алебастр
2.	2715.00.00	Нефтийн гаралтай хар тос
3.	3206.49.00	Шороон будаг



4.	3209.10.00	Хөрсжүүлэгч грунт
5.	3214.10.00	Плитаны чигжээс
6.	3214.90.00	“Кнауф”-элс, цемент, нэмэлтийн орцтой гадаргуу тэгшлэгч
7.	3501.90.00	Ээдэмцрийн цавуу
8.	3506.91.00	Эпоксид цавуу
9.	3506.99.00	Модны цавуу
10.	3807.00.00	Модны давирхай, модны давирхайн тос, модны креозот
11.	3909.50.00	Шүршдэг хөөс
12.	3910.00.00	Силикон
13.	3917.21.00	Этилений полимерийн (PE) хатуу гуурс, хоолой, шланг
14.	3917.22.00	Бохир усны хуванцар (PP) хоолой
15.	3917.22.00	Пропилений полимерийн (PP) хатуу гуурс, хоолой, шланг
16.	3917.23.00	Винилхлоридын полимерийн (PVC) хатуу хоолой, шланг
17.	3917.31.00	PVC уян хоолой
18.	3917.40.00	PAP хоолой гуравлан салаалах хуванцар салаалагч
19.	3917.40.00	Хоолой холбох хуванцар муфт
20.	3920.30.00	EPS хөөсөнцөр хавтан
21.	3921.11.00	XPS хөөсөнцөр хавтан
22.	3921.19.00	Шугам хоолой хамгаалах, дулаалах (XPE) хуйлмал ороолт
23.	3921.90.00	Гоёлын (PVC) хавтан
24.	3922.10.00	Хуванцар ванн, босоо шүршүүрт ванн, угаагуур болон тосгуур
25.	3922.20.00	Хуванцар жорлонгийн суултуур болон таг
26.	3922.90.00	Шаланд байрлуулах муу усны хоолойн трап
27.	3925.90.00	Хана шалны уулзварыг далдлах хуванцар хүрээ (плинтус)
28.	3925.90.00	Дотор ханын хавтангийн залгаас дарагч (PVC) хүрээ
29.	3925.90.00	Агааржуулалтын хуванцар сараалж
30.	3926.90.00	Цахилгааны утас далдлагч хуванцар бэлдэц
31.	3926.90.00	Разетка болон сүлжээний зориулалттай, хана болон шалан дотор суух хуванцар бортог
32.	4410.11.00	Зоргодсон хавтан
33.	44.12	Фанер, блокон хавтан, давхарлаж наасан хавтан, савхалсан хавтан
34.	4418.40.00	Бетон цутгах модон хашлага
35.	4418.50.00	Дээврийн болон бусад зориулалтын савх мод
36.	4418.79.00	Өнгөн талдаа хуулгатай паркет
37.	4811.41.00	Сүлжээний утсыг ялгаж багцлан ороох зориулалттай наалддаг цаасан тууз
38.	4814.10.00	Ханын цаас
39.	4814.20.00	Полимер гадаргуутай, угаадаг ханын цаас
40.	5703.90.00	Үсэрхэг гадаргуутай хивсэнцэр
41.	5904.10.00	Шалны хулдаас, дэвсгэр
42.	6506.10.00	Барилгын ажилд зориулсан хамгаалалтын хуванцар каскан малгай



43.	6802.21.00	Барилгын өнгөлгөөний гантиг чулуун хавтан
44.	6802.23.00	Барилгын боржин чулуун хавтан
45.	6807.10.10	Хар цаас (чулуутай, чулуугүй)
46.	6807.10.20	Давирхайт хар цаас
47.	6904.10.00	Барилгын гадна өнгөлгөөний тоосго (гоёлын)
48.	6907.21.00	Ус шингээх коэффициент нь жингийн 0.5%-иас ихгүй керамик хавтанцар, плита
49.	6907.22.00	Ус шингээх коэффициент нь жингийн 0.5%-иас их боловч, 10%-иас ихгүй керамик хавтанцар, плита
50.	6907.23.00	Ус шингээх коэффициент нь жингийн 10%-иас их керамик хавтанцар, плита
51.	6910.90.10	Угаагуур, тосгуур
52.	6910.90.30	Керамик суултуур
53.	7016.90.00	Тусгаарлах ханын зориулалттай хатжуулсан шил
54.	7019.90.00	Шугам хоолой хамгаалах, дулаалах шилэн хөвөн ороолт
55.	7209.16.00	Хуйлмал цагаан гөлмөн төмөр (урт 2м х өргөн 1м, зузаан 1мм-2мм)
56.	7212.50.00	Газардуулгын зориулалттай, зэс бүрмэл ган тууз
57.	7216.31.00	"С" төмөр
58.	7216.31.00	Швеллер
59.	72.17	Төмөр утас
60.	7225.92.00	Цайрдсан гөлмөн төмөр (1м х 2м)
61.	7228.60.00	Барилгын арматур (а-1, а-3)
62.	7228.70.00	Гангаар хийсэн булан, хэлбэрт болон сортын төмөр
63.	7304.59.00	Ширээсгүй цайрдсан ган хоолой
64.	7305.31.00	Туушид нь гагнасан, төмөр эсвэл гангаар хийсэн хоолой
65.	7306.50.00	Ширээстэй цайрдсан ган хоолой
66.	7306.61.00	Квадрат хөндлөн огтлолтой хөндий төмөр
67.	7307.21.00	Фланц
68.	7307.22.00	Эрээс гаргасан булан, тахир холбоос, цөн
69.	7307.23.00	Тулган гагнасан холбоос
70.	7307.29.00	Хоолой холбох төмөр муфт
71.	7307.92.00	Отвод (ф15-ф25, ф32-ф40, ф50-ф125)
72.	7307.99.00	РАР хоолой гуравлан салаалах төмөр салаалагч
73.	7308.30.00	Гаражийн автомат хаалга
74.	7308.30.00	Төмөр хаалга, цонх, тэдгээрийн арал, хүрээ, хаалганы босго
75.	7308.40.00	Барилгын гадна, дотор заслын ажилд зориулсан угсардаг төмөр шат, хаалт, тулгуур
76.	7308.90.00	Дүүжин тааз бэхлэх зориулалттай ховилтой төмөр зам, хавчаар, резьбатай шулуун төмөр
77.	7308.90.00	Десга-чулуун гадаргуутай, дээврийн төмөр хавтан
78.	7308.90.00	Дээврийн ус зайлуулах тосгуур, хоолой



79.	7309.00.00	Усны нөөцийн сав (24м ³)
80.	7314.39.00	Төмөр эсвэл ган утсаар хийсэн тор
81.	7317.00.00	Барилгын гадна дулаалгын хөөсөнцөр хавтан тогтоох хадаас
82.	7317.00.00	Хадаас (40мм-110мм)
83.	73.18	Эрэг, шураг, боолт, тэлэгчтэй боолт
84.	7322.19.00	Төвлөрсөн халаалтын ялтсан радиатор
85.	7324.10.00	Зэвэрдэггүй гангаар хийсэн тосгуур болон угаагуур
86.	7324.21.00	Усанд орох ширмэн ванн
87.	7326.90.00	Хоолой холбох төмөр бугуйвч
88.	7326.90.00	Автомат суулгах зам төмөр
89.	7326.90.00	Кабелийн тавиур (400мм х 200мм)
90.	7418.20.00	Сантехникийн зориулалттай, зэсээр хийсэн зүйлс болон тэдгээрийн эд анги
91.	7508.90.00	Никелийн хайлшаар хийсэн хайс
92.	7608.10.00	Халуун, хүйтэн усны хөнгөн цагаан ялтсан дотортой, хуванцар бүрээстэй хоолой (PAP)
93.	7610.10.00	Хөнгөн цагаан хаалга, цонх, тэдгээрийн хүрээ, хаалганы босго
94.	7615.20.00	Сантехникийн зориулалттай, хөнгөн цагаанаар хийсэн зүйлс болон тэдгээрийн эд анги
95.	7616.10.00	Нимгэн төмөр тавлах хөнгөн цагаан хадаас
96.	7616.91.00	Хөнгөн цагаан утсаар сүлжсэн тор, хайс, сараалж
97.	8205.59.00	Барилгын заслын төмөр шпатель
98.	8301.40.00	Хаалганы цоож
99.	8302.10.00	Хаалганы нугас
100.	8302.41.00	Барилгын зориулалттай тоног, бэхэлгээний хэрэгсэл
101.	83.07	Сантехникийн уян холбоос
102.	8311.10.00	Электрод
103.	8403.10.00	Төвлөрсөн халаалтын халуун усны тогоо
104.	8403.90.00	Халуун усны тогооны эд анги
105.	8413.50.00	Түлхэлтэт механизмтай насос
106.	8413.60.00	Эргэлтэт механизмтай насос
107.	8413.70.00	Төвөөс зугтагч үйлдлийн насос
108.	8413.81.00	Ахуйн усны насос (Wilo Helix, 18.0м ³ /ц, 55.0м)
109.	8414.51.00	Ширээ, шал, хана, цонх, тааз эсвэл дээвэрт байрлуулах зориулалттай, 125 Вт-аас ихгүй хүчин чадалтай цахилгаан хөдөлгүүрт салхилуур
110.	8414.59.00	Барилгын доторх агаар сэлгэлт, удирдлагын системээр ажиллах сэнс /салхивчийн/ (e1280 e2 01, 1600м ³ /ц, 300п), (e1250 e2 06, 1200м ³ /ц), (e1315 e2 01, 200м ³ /ц, 300п), (FFH250 EC 10, 800м ³ /ц, 250па)
111.	8414.59.00	Салхивчийн зориулалттай төхөөрөмж (SI 12040 e3j 2110)
112.	8414.59.00	Салхивчийн зориулалттай төхөөрөмж Roto-k (4200h wkjr, 7600h wkjr)



113.	8414.59.00	Салхивчийн зориулалттай төхөөрөмж Hг-95 350h-ec
114.	8414.59.00	Салхивчийн зориулалттай төхөөрөмж Mps 560 d4 30
115.	8414.90.00	Агааржуулалтын сэнс, салхивчийг холбох холбоос (Vm200-Vm400, Vs12040-Vs12060, Vs10050 02)
116.	8415.82.00	Заал, танхимыг хүйтэн болон дулаан агаараар хангах зориулалттай хөргөлтийн чиллер (q-216 ктв wsat-xee 802)
117.	8418.61.00	Дулааны насос (Yonos PLCO 25/1-6)
118.	8481.10.00	Хөвүүртэй хий авагч
119.	8481.10.00	Даралт сааруулагч хавхлага
120.	8481.30.00	Хяналтын (буцаж ухардаггүй) хавхлага (RSK-280d, RSK-315d)
121.	8481.40.00	Аваарын эсвэл суллах хавхлага
122.	8481.80.00	Хэмжин түгжигч хаалт
123.	8481.80.00	Хуваарилах коллектор
124.	8481.80.00	Дулааны шугаманд суурилуулах температурын автомат хаалт
125.	8481.80.00	Шүршүүр, угаагуурын холигч
126.	8504.10.00	Хийн ламп эсвэл хоолойн балласт эсэргүүцэл
127.	8504.21.00	650 кВА-аас ихгүй чадалтай шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатор
128.	8504.22.00	650 кВА-аас их боловч 10000 кВА-аас ихгүй чадалтай, шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатор
129.	8504.23.00	10000 кВА-аас их чадалтай, шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатор
130.	8504.31.00	1 кВА-аас ихгүй чадалтай трансформатор
131.	8504.32.00	1 кВА-аас их боловч 16 кВА-аас ихгүй чадалтай трансформатор
132.	8504.33.00	16 кВА-аас их боловч 500 кВА-аас ихгүй чадалтай трансформатор
133.	8504.34.00	500 кВА-аас их чадалтай трансформатор
134.	8504.40.00	Статик хувиргагч
135.	8504.40.00	Давтамж хувиргагч 380в, (1квт-9квт)
136.	8504.40.00	Цахилгаан тэжээл баригч (3kbt UPS)
137.	8504.50.00	Бусад индуктор
138.	8504.90.00	Трансформаторын эд анги
139.	8516.10.00	Айлуудын ариун цэврийн өрөөнд байрлуулах, эзлэхүүний ус халаагч (80л, 1.6кВт)
140.	8516.29.00	Халуунаар үлээгч дулааны хөшиг (Vce-b-150-e-zp-0-0, Vce-b-200-e-zp-0-0)
141.	8516.79.00	Цахилгаанаар ажилладаг алчуур хатаагч
142.	8517.62.40	Мультиплексер, дамжуулагч, хүлээн авагч, конвертер
143.	8517.62.90	Рое-той сэлгэгч төхөөрөмж
144.	8517.69.00	Cat6 patch panel 24 оролттой
145.	8517.69.00	Холбооны төхөөрөмж угсрах самбар
146.	8517.70.00	Сүлжээний төхөөрөмжийн эд анги
147.	8518.40.00	Авиа давтамжийн цахилгаан өсгөгч



148.	8518.50.00	Дууны цахилгаан өсгөгчийн иж бүрдэл
149.	8518.90.00	Өсгөгчийн эд анги
150.	85.21	Дүрс бичих эсвэл сэргээгч аппарат
151.	8531.10.00	Галын дохиоллын ерөнхий станц
152.	8531.10.00	Галын дохиоллын хяналтын систем
153.	8531.10.00	Хулгайн эсвэл галын аюулын дохиолол болон тэдгээртэй төстэй дохиоллын төхөөрөмж
154.	8531.20.00	Удирдлагын өрөөнөөс гал хаана гарч байгааг хянах зориулалтай, галын утааны оптик электрон мэдрэгчтэй хаягтай мэдээлэгч
155.	8531.80.00	Дохиоллын бусад төхөөрөмж
156.	8531.80.00	Ослын дуут дохиоллын удирдлагын модуль
157.	8531.90.00	Дохиоллын төхөөрөмжийн эд анги
158.	8535.21.00	72.5 кВ-оос бага хүчдэлийн хэлхээг автоматаар таслагч
159.	8535.29.00	1000 В-оос их хүчдэлийн бусад хэлхээг автоматаар таслагч
160.	8535.30.00	1000 В-оос их хүчдэлийн гүйдэл салгагч болон таслагч
161.	8535.40.00	1000 В-оос их хүчдэлийн аянга сарниулагч, хүчдэл хязгаарлагч болон хүчдэлийн огцом өөрчлөлтийг дарагч
162.	8535.90.00	1000 В-оос их хүчдэлийн бусад залгуур болон бусад холбогч, хуваарилагч хайрцаг
163.	8535.90.00	Цахилгааны утас холбогч муфт
164.	8536.10.00	1000 В-оос ихгүй хүчдэлийн гал хамгаалагч
165.	8536.20.00	1000 В-оос ихгүй хүчдэлийн хэлхээг автоматаар таслагч
166.	8536.30.00	1000 В-оос ихгүй хүчдэлийн цахилгаан хэлхээг хамгаалах бусад төхөөрөмж
167.	8536.41.00	60 В-оос ихгүй хүчдэлийн реле
168.	8536.49.00	Завсрын болон фазын дарааллын реле
169.	8536.50.00	Сэлгэн залгуур
170.	8536.50.00	Соронзон залгуур (230v, 4a, 230v, 9a)
171.	8536.50.00	Цахилгааны самбарт угсрагдах зориулалттай кноп
172.	8536.50.00	Гэрлийн унтраалга
173.	8536.61.00	Чийдэнгийн патрон
174.	8536.69.00	Залгуур сэрээ, разетка
175.	8536.70.00	Шилэн кабелийн холбогч
176.	8536.90.00	Цахилгаан дамжуулагчийг төхөөрөмжтэй холбох төгсгөвч, клемм (1.5мм ² , 6a),(2.5мм ² , 10a)
177.	8536.90.00	Газардуулагч шин dIn (35мм)
178.	8536.90.00	Хэлхээнд үүссэн илүүдэл цахилгааныг газардуулах цэнэг шавхагч (опс1-в/4)
179.	8536.90.00	Шилэн кабелийн төхөөрөмж
180.	8536.90.00	Сүлжээний утсыг төхөөрөмжтэй холбогч төгсгөвч
181.	8536.90.00	Цахилгааны утас холбогч муфт
182.	8537.10.00	Контроллер (24b ac/dc modbus, Lcd дэлгэц ао-4, то-4 , тг-4, йг-4)



183.	8537.10.00	Шилэн кабелийн шөрмөсийн хуваарилах хайрцаг
184.	8538.10.00	1000 В-оос ихгүй хүчдэлийн цахилгааны хяналт, хуваарилалтын зориулалттай самбар, панель, консоль, ширээ, хуваарилах щит болон цахилгаан хэрэгслийн суурь
185.	8538.10.00	Цахилгааны төхөөрөмж угсрах төмөр самбар
186.	8539.10.00	Бин битүү цацрагт чийдэн
187.	8539.22.00	200 Вт-аас ихгүй чадлын, 100 В-оос их хүчдэлийн цахилгаан катодтой чийдэн
188.	8539.50.00	Цахилгааны самбарт угсрагдах зориулалттай LED диодтой нүдэн гэрэл
189.	8542.31.00	Санах ой, конвертер, логик схем, өсгөгч, цаг болон цагийн механизм, эсвэл өөр бусад схемтэй угсрагдсан буюу угсрагдаагүй процессор болон хянах хэрэгсэл
190.	8544.11.00	Тусгаарлагчтай зэсэн ороомог утас
191.	8544.19.00	Тусгаарлагчтай бусад ороомог утас
192.	8544.20.00	Коаксиаль кабель болон коаксиаль цахилгаан дамжуулагч
193.	8544.42.00	Cat6 patch cord 0.5м холбогч кабель
194.	8544.42.00	Холбогч хэсгээр тоноглогдсон 1000 В-оос ихгүй хүчдэлийн бусад цахилгаан дамжуулагч утас
195.	8544.42.00	Олон залгуурт уртасгуур
196.	8544.49.00	Физик кабель ТТПЭП (100х2 хосын)
197.	8544.49.00	Зэс голтой, тусгаарлагчтай, уян кабель
198.	8544.49.00	Бусад 1000 В-оос ихгүй хүчдэлийн бусад цахилгаан дамжуулагч утас
199.	8544.60.00	1000 В-оос их хүчдэлийн бусад цахилгаан дамжуулагч утас
200.	8544.70.00	Оптик мяндсан кабель, шилэн кабель
201.	8544.70.00	Салаалагч шилэн кабель
202.	9026.10.00	Шингэний зарцуулалт, түвшинг хэмжих, хянах төхөөрөмж
203.	9026.20.00	Даралт хэмжих, хянах
204.	9026.80.00	Хий эсвэл шингэний хувьсах бусад хэмжигдэхүүнийг хэмжих, хянах зориулалтын бусад багаж, аппарат
205.	9026.80.00	Алсын хяналттай дулааны тоолуур
206.	9026.90.00	Хий эсвэл шингэний урсгал зарцуулалт, түвшин, даралт буюу хувьсах бусад хэмжигдэхүүнийг хэмжих, хянах зориулалтын багаж, аппаратын эд анги болон тоног хэрэгсэл
207.	9028.10.00	Хийн тоолуур
208.	9028.20.00	Шингэний тоолуур
209.	9031.80.00	Галын дулаан мэдрэгч
210.	9032.10.00	Удирдлага ТЕМ-035
211.	9032.10.00	Өрөөний термостат (230в хэк/хск 6а, modbus) өвөл зуны горимтой, lcd дэлгэц (ao-1, тг-5)
212.	9405.10.00	Хөдөлгөөн мэдрэгчтэй, хана, таазанд суурилуулах LED гэрэлтүүлгийн хэрэгсэл



213.	9405.10.00	Ханын эсвэл таазны цахилгаан гэрэлтүүлгийн хэрэгсэл
214.	9405.40.00	Аваарын гарц, чиглэл заах зориулалттай, LED гэрэлтүүлгийн хэрэгсэл
215.	9405.60.00	Шингэн кристалл төхөөрөмж (LCD) эсвэл гэрэл цацруулагч диод (LED) угсарсан заалтын гэрлэн самбар
216.	9405.60.00	Гэрлэн хаяг, гэрлэн самбар болон эдгээртэй төстэй зүйлс

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 09 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн
20.7.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Ш.Солонго, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн О.Мөнхболд, А.Түвшинтөгс нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Иргэн О.Мөнхболд, М.Мөнхжаргал, А.Түвшинтөгс нар
Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл,
гомдол ирүүлжээ. Үүнд:**

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалтад “тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж

шийдвэрлэсэн.”, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэгт “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн тухайд: Дээрх зохицуулалт нь нэгдүгээрт, хэрвээ тендерт оролцогч байгууллага, хувь хүн гомдол гаргах тохиолдолд заавал 20 сая төгрөгөөс хэтрэхгүй хэмжээний баталгаа хөрөнгийг өөрийн нэр дээр байршуулах; хоёрдугаарт, гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хэн бүхэн хууль, шүүхийн өмнө адил боломжоор хангагдаж, үүрэг, хариуцлага хүлээх тухай юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг үндэс угсаа хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлаж, аль нэг хэсэгт нь давуу буюу дутуу эрх олгох, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлөх хууль гаргаж болохгүй гэсэн үг юм. Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулсан нэмэлт заалтууд нь бусдын гомдол гаргаж эрхээ хамгаалах боломжийг мөнгөн хэлбэрээр хязгаарлаж, тэгш боломжийг хааж, хөрөнгө чинээгээр ялган заагласан байна.

Өөрөөр хэлбэл, тендерт оролцогч иргэн, байгууллага тендерийн процедур хууль бусаар явагдсан гэж үзсэн тохиолдолд гомдол гаргах эрх нээлттэй байх ёстой. Тендерт оролцогч бүхий л талуудыг гомдол гаргах эрх, боломжоор эрх тэгш хангах байдлаар хуульд зохицуулах шаардлагатай. Учир нь хууль хэн нэгнийг ялгаварласан, тэгш бус байдлыг бий болгосон байж болохгүй. Гэтэл хуульд мөнгөтэй байгууллага, хувь хүн гомдол гаргах боломж, давуу талыг бий болгосон байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. ...” гэж заасныг зөрчсөн тухайд: Тендерийн баталгааны зорилго нь гомдол үндэслэлгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангуулах хэрэгсэл биш юм. Өөрөөр хэлбэл, алданги, торгууль буюу анз биш болно. Тендерийн баталгаа гэж хуульд тодорхойлсноор гэрээ байгуулах, эсхүл тендерийн хүчинтэй байх хугацаа дуустал тендер хүчин төгөлдөр байх, шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах, хариуцлагатай оролцохоо баталгаажуулж



тендерт оролцогчоос захиалагчид ирүүлсэн банкны баталгаа болон Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг ойлгоно. Тендерийн баталгааны үндсэн зорилго нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах, оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэх юм. Үүрэг үүссэн нөхцөлд үүргийн гүйцэтгэлийн баталгааг хангуулах боломж үүсдэг. Гэтэл төрийн байгууллагад гомдол гаргах нь гомдол гаргаж буй этгээдийн өөрийн эрх бөгөөд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг үйл ажиллагаа. Иймээс үүрэг үүсгээгүй оролцогчийн тендерийн баталгаанаас мөнгө суутган авах нь огт үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлж гомдол гаргасных нь төлөө тухайн иргэн, хуулийн этгээдийн өмч хөрөнгө болох тендерийн баталгаанд байршуулсан мөнгөн хөрөнгийг нь “үндэслэлгүй гомдол гаргасан” гэдгээр хураан авах нь хувийн өмчид халдсан ноцтой заалт гэж үзэж байна. Иймд тендерийн баталгаанаас үндэслэлгүйгээр хөрөнгө хураан авахаар нэмж зохицуулснаараа Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчиж байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтыг зөрчсөн тухайд: Иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагад гомдол гаргах эрх нь өөрийн зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалах, сэргээлгэх үндсэн эрх мөн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт “Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно” гээд гурван үндэслэлийг дурдсан. Түүний нэг үндэслэл нь “тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн” тохиолдол багтаж байгаа бөгөөд гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байхаар заасан.

Энэ нь тендерийн маргаантай холбоотой асуудлаа төрийн байгууллагаар хянуулах эрхийг нь хязгаарласан. Тендерт оролцогч нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт; захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана. Гомдол хүлээн авч буй байгууллага нь тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, өргөдлийг үнэн, зөв, хуульд заасны дагуу шударгаар шийдвэрлэх үүргтэй. Харин гомдол үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүйгээс шалтгаалаад шалгуур тогтоож, үндэслэлгүй тохиолдолд торгууль хэлбэрээр 20 сая төгрөгийг хураан авах нь огт үндэслэлгүй юм. Иргэний өргөдөл, гомдол гаргаж, төрийн байгууллагаар шийдвэрлүүлэх эрх ноцтой зөрчигдөж байна.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэснийг зөрчсөн тухайд: Хууль тогтоогчийн хувьд дээрх заалтаар гомдол гаргахад урьдчилсан нөхцөл буюу шалгуурыг зааж өгсөн. Тус шалгуур нь гомдол гаргах хүсэл зоригийг хязгаарласан, гомдол үндэслэлгүй нь тогтоогдсон бол тендерийн баталгаанаас 20 сая төгрөгийг хураалгах үр дагаврыг шууд үүсгэж байна.

Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж эцэслэн шийдвэрлэх эрх шүүхэд байгаа. Эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй тендерт оролцогч өөрийн гаргаж буй аливаа гомдлоо үндэслэлтэй гэж үзээд шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллага болон шүүхэд ханддаг. Гэтэл ийнхүү шударга шүүхээр шүүлгэх гэтэл “гомдол үндэслэлгүй бол тендерийн баталгаа мөнгөө алдана, шүүхээр хангагдах л гомдол гаргах ёстой” гэсэн ойлголт, хязгаарлалтыг тавьж байгаагаараа иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хязгаарлаж, халдсан зүйл болжээ.

Үүний үр дагавар нь гомдол гаргах шалгуур үзүүлэлтийг үндсэн эрхийг зөрчин тогтоосноор хуулийн этгээд болон иргэд гомдол гаргахаас зайлсхийх, гомдол гаргах тоо багасна. Үүний цаагуур хууль бус тендер шалгаруулалт дээд шатны байгууллага болон шүүхийн хяналтаас гарч, улам гаарах туйлын ноцтой үр дагавартай юм. Ардчилсан нийгмийн суурь үнэт зүйл болох өөрсдийн эрх, ашиг сонирхлоо шударга шүүх, захиргааны байгууллагаар хамгаалуулах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх боломж алдагдаж байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухайд: Аливаа гомдлыг гаргахад урьдчилсан байдлаар мөнгө байршуулах явдал нь улсын тэмдэгтийн хураамжийн шинж бөгөөд тендертэй холбоотой захиалагчийн шийдвэрт гомдол гаргахын өмнө урьдчилсан байдлаар мөнгө байршуулсны дараа шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж ... гэнэ.”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Тэмдэгтийн хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа дараахь этгээд тэмдэгтийн хураамж төлөгч байна.” гэж заасан. Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах бол урьдчилсан байдлаар мөнгө байршуулах шаардлага тавьж буй нөхцөл нь улсын тэмдэгт байх нөхцөлийг бүрдүүлж буй тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тусгагдсан байх ёстой. Гэтэл байршуулах мөнгөн төлбөрийн талаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тусгагдаагүй. Түүнчлэн тендертэй холбоотой захиалагчийн шийдвэрт гомдол гаргах нь төрийн эрх бүхий байгууллагаас үйлчилгээ авч буй үйл ажиллагаа биш юм.



Өөрөөр хэлбэл, шүүхэд хандан нэхэмжлэл гаргаж буй аливаа иргэн, хуулийн этгээд нь улсын тэмдэгтийн хураамжаас өөр ямар нэгэн төлбөр мөнгө, тендерийн баталгааг барьцаалах, баталгаа гаргах, улмаар гомдлоо үндэслэлтэй эсэхэд дэнчин тавих талаарх зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд байхгүй билээ. Иймээс хууль тогтоогчийн зүгээс хуульд эдгээр хууль зөрчсөн заалтуудыг нэмж оруулснаар төрийн худалдан авах ажиллагаанд тендерт оролцогчийн эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ зөрчсөн байна.

Иймд дээрх үндэслэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн дараах агуулга бүхий хариу тайлбарыг Үндсэн хуулийн цэцэд ирүүлжээ. Үүнд:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалтад “тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.”, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэгт “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.” гэж заасан нь дараах үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтыг зөрчөөгүй талаар:

1.1.Худалдан авах ажиллагаанд оролцогч этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйлд заасны дагуу захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлүүлэх, захиалагчийн шийдвэрт гомдол гаргах, шүүхэд гомдол гаргах, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах бүрэн эрхтэй ба шүүх гомдлыг эцэслэн шийдвэрлэх, эд хөрөнгийн хохирлоо шүүхийн журмаар гаргуулах хууль, эрх зүйн орчин хэвээр үйлчилж байна.

Монгол Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт,

өөрчлөлтийг батлан гаргахдаа дээрх заалтуудад иргэний гомдол гаргах эрхийг хязгаарласан, хөрөнгө чинээнээс хамааруулан ялгамжтай байдлаар нэмэлт нөхцөл шаардлага тогтоогоогүй болно.

1.2.Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тендерт оролцогчоос гомдол гаргахад 20 сая хүртэлх төгрөгийн барьцаа хөрөнгийг гаргуулахаар заасан байсныг хэлэлцүүлгийн явцад хянан үзэж, төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийг зөрчиж болзошгүй гэсэн үндэслэлээр хуулийн төслөөс хасаж баталсан. Тиймээс иргэний мэдээлэлд дурдсан тендерт оролцогчдыг гомдол гаргахад нь ялгаварласан, тэгш бус байдлыг бий болгосон гэж тайлбарласан нь үндэслэлгүй байна.

Тендерт оролцогч нь тендер ирүүлэхдээ хуульд заасны дагуу тухайн ажил, бараа, үйлчилгээний тодорхой хувиар тендерийн баталгааг өмнө нь гаргуулж захиалагчид ирүүлдэг. Өөрөөр хэлбэл, энэхүү мөнгөн хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргахаас өмнө захиалагчид хүргүүлсэн байдаг бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гомдлыг хянан шийдвэрлэхэд тендерт оролцогч буюу гомдол гаргагчид өөрийн нэр дээр шинээр хөрөнгө байршуулах шаардлага тавиагүй болно.

1.3.Хууль тогтоогч худалдан авах ажиллагааны практикт гарч байгаа худалдан авах ажиллагааг хойшлуулдаг зохисгүй хандлага байгааг засах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага үүссэнтэй холбоотойгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу тендер шалгаруулалттай холбогдох маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл төсвийн хөрөнгө оруулалтын ажил эхэлдэггүй. Худалдан авах ажиллагаанд ихээхэн цаг хугацаа зарцуулснаар тухайн оны төсвийн хөрөнгө оруулалт буцаан татагддаг, улс орны бүтээн байгуулалтын ажил хоцорч, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүйгээс төсөвт өртөг өсөх, хууль ёсны дагуу шударгаар шалгарсан тендерт оролцогчид ч мөн гэрээ байгуулж чадахгүй байх зэргээр нийтийн эрх ашгийг хөндсөн сөрөг үр дагаврыг бий болгодог.

Ингэснээр оролцогчийг хөрөнгө хэмжээгээр ялгаварлан гомдол гаргах эрхийг хязгаарлаж байгаа хэрэг биш, харин нийтийн өмчөөр худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ нэгэнт гаргасан бол тухайн этгээд худалдан авах бүхий л ажиллагаандаа, тендерийн баримт бичгээ ирүүлэхээс эхлэн худалдан авах ажиллагаа дуусах, гомдол гаргах бүх шатанд хариуцлагатай оролцохыг үүрэгжүүлсэн юм.



Энэ нь төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр өгөөжид сөргөөр нөлөөлдөг аливаа үйлдлийн хууль зүйн боломжийг хаах, нөгөө талаас тендерт оролцогчийн зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан болно.

1.4.Тендерийн маргаан үүсэхэд нийтийн ашиг сонирхол хөндөгддөг. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг барих ажил хойшилсны үр дагаврыг иргэд хүртэх ба Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон иргэний сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах үндсэн эрх, эрх чөлөө алдагдахад хүрдэг.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зорилт нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үр ашигтай худалдан авалт хийж, иргэддээ чанартай үйлчилгээ хүргэхэд оршдог. Энэхүү хууль нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалж байгаа нэг талын зохицуулалттай тул нийтийн эрх зүйд хамаарах төрөлжсөн хууль юм. Нийтийн эрх зүйн харилцаанд иргэд, хуулийн этгээд оролцоходоо нийтийн ашиг сонирхолд захирагдах, нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр нийтийн ашиг сонирхлын хүсэл зориг илэрхийлэгддэг.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчөөгүй талаар:

Хувийн өмчийг хууль бусаар хураан авах нь хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хариу төлбөргүйгээр төрд авах ажиллагаа ба маргаж буй хуулийн заалтад хууль зүйн ийм агуулга байхгүй болно. Тендерийн баталгаа нь тухайн тендерт оролцогч хариуцлагатай оролцохоо илэрхийлж байршуулсан мөнгөн хөрөнгө буюу баталгаанд дурдсан нөхцөл бий болмогц түүнээс үүрэг гүйцэтгүүлэхийг зөвшөөрсөн амлалт юм.

Иргэн, хуулийн этгээд нь тендер шалгаруулалтад сайн дурын үндсэн дээр, захиалагчаас тавьсан шалгуур үзүүлэлтийг хүлээн зөвшөөрч оролцож байгаа бөгөөд тендерийн баталгаа нь энэхүү захиалагчаас тогтоож байгаа шалгууруудын нэг хэсэг юм. Нэгэнт тендерт оролцохоо илэрхийлсэн бол хуульд заасан нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрч түүнийг биелүүлэх үүрэг үүснэ.

Худалдан авах ажиллагаатай холбоотой маргааны нийгмийн зардал өндөр байгаа онцлогийг харгалзан хуульчилсан энэхүү зохицуулалтыг Үндсэн хуулийн хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно гэснийг зөрчсөн хэмээн мэдээлэл гаргагч тайлбарласан нь үндэслэлгүй юм.

Үндсэн эрхийг хөндөхгүйгээр оролцогчид тавих шаардлагыг тусгайлан тогтоох нь эрхээ хэрэгжүүлэхэд төвөгтэй байдлыг бий болгох

биш, харин нийгмийн ашиг, сонирхлыг хамгаалахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн үндсийг бүрдүүлэх үүргээ өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн болно.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчөөгүй талаар:

Худалдан авах ажиллагаанд оролцогч этгээд эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 9 дүгээр бүлэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмын дагуу захиргааны болон шүүхийн журмаар гомдлоо гаргах эрхтэй. Захиргааны шийдвэрийг давж заалдах, шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулах, эд хөрөнгийн хохирлоо шүүхэд нэхэмжлэн гаргуулах хууль зүйн бүх боломж гомдол гаргагч иргэн, хуулийн этгээдэд нээлттэй байгаа бөгөөд түүнд ямар нэгэн хуулийн хязгаарлалтыг дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тогтоогоогүй болно.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй талаар:

Тендерийн баталгаа нь хариуцлагын мөнгөн төлбөр, үнэ цэнийг илэрхийлнэ. Мөнгөн төлбөрийг тогтоосон хууль тогтоогчийн хүсэл зориг нь гомдол гаргасан иргэнээс төлбөр гаргуулахыг зорилгоо болгоогүй бөгөөд худалдан авах ажиллагаанд гомдол гаргахад хариуцлагатай байхыг тендерийн баталгаагаар дамжуулан бий болгоход чиглэсэн тул түүнийг төр үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шууд авдаг улсын тэмдэгтийн хураамжтай адилтгаж, зохицуулалт хийх боломжгүй юм.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу тэмдэгтийн хураамжийг үйлчилгээ үзүүлэхээс өмнө улсын болон орон нутгийн төсвийн дансанд урьдчилан тушаадаг ба энэ нь нэхэмжлэлийн бүрдүүлбэр хэсэгт хамаардаг.

Харин тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтын оролцогчийн ирүүлсэн тендерийн баталгаа нь зөвхөн тендерийн баталгаа гэх хууль зүйн баримт бичиг бөгөөд тендерт оролцогч нь тухайн баталгааг банк болон үнэт цаасны үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр гаргуулдаг.

Иргэний мэдээлэлд дурдсанаар шүүхэд гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлдөгтэй адилтган захиргааны байгууллагад гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр журамлах нь тухайн этгээдийн гомдол гаргахад нэмэлт шаардлагыг тогтоож байгаа эсэх, энэ



эрхийн хязгаарлалт мөн эсэхийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд судлан үзэх шаардлага үүсэх ба энэ нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр цаашид анхаарвал зохих асуудал юм.

Иймээс Монгол Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч миний хүргүүлж байгаа тайлбарыг судлан үзэж, хуульд заасны дагуу шийдвэрлэхийг хүсэж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс маргаанд холбогдох тайлбар, баримт, мөн холбогдох хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын байнгын хороо болон Чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл зэргийг Улсын Их Хурлын Тамгын газраас гаргуулан авсан болно.

ҮНДЭСЛЭЛ

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх журам, тендерт оролцогчдын эрх зүйн байдлыг тогтоох нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсгийн зохицуулалтаар тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох, түүний дээд хэмжээ 20 сая төгрөг байхаар хуульчилсан нь тендерт оролцогчдод нийтлэг үйлчлэх зохицуулалт байна.

3.Дээрх хуулийн 54, 55 дугаар зүйлд захиалагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах захиргааны байгууллагын харьяалал, шийдвэрлүүлэх журмыг тодорхой тусгасан байна. Мөн тус хуулиар тендерт оролцогч шүүхэд гомдол гаргах боломжийг хуульчилсан бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг тусгай журмаар хянан шийдвэрлэхээр заажээ. Ийнхүү шүүхээр шийдвэрлүүлэхэд хуулиар аливаа нэмэлт шалгуур, хязгаарлалтыг бий болгоогүй байна.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлд “тендерийн

баталгаа”-г гэрээ байгуулах хүртэл, эсхүл тендерийн хүчинтэй байх хугацаа дуустал тендер хүчин төгөлдөр байх, шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах, хариуцлагатай оролцохоо баталгаажуулах зорилгоор гаргуулахаар заасныг үзвэл цаашид хууль тогтоогч хуулийн заалт хоорондын уялдааг хангаж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага байгааг дурдах нь зүйтэй юм.

Дээрхээс үзэхэд, мэдээлэл гаргагч нарын мэдээллийн үндэслэл, шаардлагын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалтад “тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.”, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэгт “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.” хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... хөрөнгө чинээ ... -гээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. ...”, мөн зүйлийн 12 дахь заалтад “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;”, мөн зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.



2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Г.ТУУЛХҮҮ

ГИШҮҮД

Д.СОЛОНГО

Б.БУЯНДЭЛГЭР

Ш.СОЛОНГО

Г.БАЯСГАЛАН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,5

Индекс: 200003